



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС - PMI

2023.I
улирал

2023 оны 5 дугаар сарын 9-ний өдөр

МОНГОЛБАНК

Энэхүү үзүүлэлтийг олон улсад нийтлэг ашиглагддаг аргачлалын дагуу бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид болон олон нийтийн хэрэгцээнд зориулж улирлын давтамжтай тогтмол гаргаж байна.

1. Худалдан авалтын менежерийн индекс (PMI)

Ерөнхий индекс: Монгол Улсын худалдан авалтын менежерийн ерөнхий индексийн утга 2023 оны I улиралд өмнөх улирлаас 2.1 нэгж хувиар өсөж тэлэлтийн мужид **54.4%**-тай гарлаа. Өмнөх улирлын үзүүлэлтээс өсөхөд үйлдвэрлэл, бараа материалын нөөцийн индексийн утга өссөн нь голлон нөлөөлөв /Зураг 1-2/.


Нийлмэл индекс: Нийлмэл индексүүдийн хувьд ажил эрхлэлт 7, үйлдвэрлэлийн индекс 4 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 9 улирал дараалан, шинэ захиалга 2022 оны I улирлаас хойш анх удаа агших мужид тус тус гарлаа. Үйлдвэрлэлийн индекс уг судалгаа эхэлснээс хойшхи хамгийн хурдацтай өсөлтийг үзүүлснээс гадна бараа материалын нөөцийн индексийн утга өмнөх улирлаас огцом өсөж, 2 улирлын дараа дахин тэлэлтийн мужид шилжсэн байна. /Зураг 2/.

Салбарын индекс: Аж үйлдвэр болон үйлчилгээний салбар тус бүр 4 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол барилгын салбарын индекс 9 улирал дараалан агших мужид гарлаа. Харин худалдааны салбар анх удаа тэлэлтийн мужид шилжиж өссөн байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад худалдаа 15.0, барилга 14.8, үйлчилгээ 3.5 нэгж хувиар тус тус өссөн бол аж үйлдвэрийн салбарын индексийн утга 5.6 нэгж хувиар буурлаа /Зураг 3/.


Зураг 1. Ерөнхий индекс



Зураг 2. Нийлмэл индекс




Зураг 3. Ерөнхий индекс, салбараар



Үйлдвэрлэлийн индексийн утгыг бодит ДНБ-ий улирлын өөрчлөлттэй харьцуулан харахад үйлдвэрлэлийн индексийн утга 50%-аас их үед улирлын ДНБ өсөлттэй гарсан байна. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн индексийн утга нь улирлын ДНБ-ий өөрчлөлтийг бүрэн тайлбарлах бөгөөд тайлант улирлын үйлдвэрлэлийн индексийн утга 60.3%-тай гарсан нь 2023 оны I улиралд ДНБ өмнөх улирлаас нэмэгдэх төлөвтэйг харуулж байна /Зураг 4/.

Зураг 4. Бодит ДНБ-ий улирлын өөрчлөлт болон үйлдвэрлэлийн индекс




2. Салбарын үзүүлэлтүүд

Аж үйлдвэр: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд ажил эрхлэлт 7, үйлдвэрлэлийн индексийн утга 4 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа, бараа материалын нөөцийн индексийн утга тэлэлтийн мужид шилжлээ. Харин шинэ захиалга 3 улирлын дараа агших мужид шилжиж буурсан байна. Өмнөх улиралтай харьцуулахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа, бараа материалын нөөцийн индексийн утга өссөн дүр зурагтай байна /Зураг 5/.

Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд бүтээгдэхүүний үнэ болон түүхий эд материалын үнэ тус бүр 9, худалдан авалтын тоо хэмжээ 6, дуусаагүй үйлдвэрлэл 4, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индексийн утга 2 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан байна. Харин бэлэн бүтээгдэхүүн агших мужаас тэлэлтийн мужид шилжиж, өмнөх улирлаас 27.4 нэгж хувиар өслөө /Хүснэгт 1/.

Зураг 5. Аж үйлдвэрийн салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын нэмэлт үзүүлэлтүүд


Үзүүлэлт	2022.III	2022.IV	2023.I
Дуусаагүй үйлдвэрлэл	63.7↑	50.7↓	51.4↑
Бэлэн бүтээгдэхүүн	52.7↓	35.5↓	62.9↑
Бүтээгдэхүүний үнэ	83.5↓	69.4↓	79.5↑
Худалдан авалтын тоо хэмжээ	65.6↓	57.6↓	52.6↓
Түүхий эд, материалын үнэ	93.8↑	89.7↓	87.3↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	38.4↓	60.7↑	55.2↓

Барилга: Тус салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга буурч тэлэлтийн мужаас агших муж руу шилжсэн бол шинэ захиалга, үйлдвэрлэл болон бараа материалын нөөцийн индексийн утга тус бүр 9 улирал дараалан агших мужид гарлаа. Харин ажил эрхлэлт анх удаа тэлэлтийн мужид шилжиж өссөн байна. Өмнөх улиралтай харьцуулахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаанаас бусад үзүүлэлтүүдийн индексийн утга өссөн байна. /Зураг 6/.

Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд борлуулалтын үйл ажиллагааны индексийн утга агших мужаас тэлэлтийн муж руу шилжиж, мөн түүхий эд, материалын үнийн индексийн утга 9 улирал, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индексийн утга 2 улирал дараалан тэлэлтийн мужид гарсан байна. Харин орон сууцны зах зээлийн идэвхжил 6, худалдан авалтын тоо хэмжээ, барилга, угсралтын үйл ажиллагаа, болон туслан гүйцэтгэгч ашиглалтын индексийн утга тус бүр 9 улирал дараалан агших мужид гарчээ. Өмнөх улиралтай харьцуулахад бүх үзүүлэлтүүдийн индексийн утга өслөө /Хүснэгт 2/.

Дотоод худалдаа: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд шинэ захиалга, үйлдвэрлэл (борлуулалт), ажил эрхлэлтийн индексийн утга тэлэлтийн мужид шилжиж, бараа материалын нөөцийн индексийн утга 2 улирал дараалан тэлэлтийн мужид гарлаа. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 9 улирал дараалан агших мужид гарсан байна. Өмнөх улиралтай харьцуулахад


Зураг 6. Барилгын салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 2. Барилгын салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022.III	2022.IV	2023.I
Худалдан авалтын тоо хэмжээ	35.2↓	28.0↓	40.0↑
Түүхий эд, материалын үнэ	94.8↑	91.7↓	95.6↑
Орон сууцны зах зээлийн идэвхжил	40.9↓	22.1↓	42.4↑
Борлуулалтын үйл ажиллагаа	42.7↑	25.0↓	74.6↑
Барилга, угсралтын үйл ажиллагаа	36.0↓	23.1↓	37.2↑
Туслан гүйцэтгэгч ашиглалт	47.7↑	34.6↓	49.3↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	36.3↓	57.1↑	58.2↑

Зураг 7. Дотоод худалдааны салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга буурсан бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга өслөө /Зураг 7/.

Тус салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд түүхий эд, материалын үнэ болон худалдан авсан барааны хэмжээний индексийн утга тус бүр 9 улирал дараалан тэлэлтийн мужид гарч байгаа бол хүлээгдэж буй борлуулалт 3 улирал дараалан агших мужид гараад байна. Өмнөх улиралтай харьцуулахад худалдан авсан барааны хэмжээний индексийн утга өссөн бол түүхий эд, материалын үнэ болон хүлээгдэж буй борлуулалтын индексийн утга тус бүр буурлаа /Хүснэгт 3/.


Үйлчилгээ: Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа тэлэлтийн мужаас агших муж руу шилжсэн бол ажил эрхлэлт 6, үйлдвэрлэл 4, шинэ захиалга 2 улирал дараалан тус тус тэлэлтийн мужид гарлаа. Үзүүлэлтүүдийг өмнөх улиралтай харьцуулахад шинэ захиалга, үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийн индексийн утга өссөн бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга буурсан байна /Зураг 8/.

Салбарын нэмэлт үзүүлэлтүүдийн хувьд түүхий эд, материалын үнийн индексийн утга 9, үйлчилгээний үнийн индексийн утга 7, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индексийн утга 2 улирал дараалан тэлэлтийн мужид гарчээ. Харин дуусаагүй ажил үйлчилгээний индекс анх удаа агших мужид шилжсэн. Үйлчилгээний үнэ, бизнесийн үйл ажиллагааны төлөвийн индексийн утга өмнөх улиралтай харьцуулахад өссөн бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга буурсан үзүүлэлттэй байна /Хүснэгт 4/.

Хүснэгт 3. Дотоод худалдааны салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022.III	2022.IV	2023.I
Түүхий эд, материалын үнэ	86.8↑	86.4↓	72.8↓
Худалдан авсан барааны хэмжээ	82.6↑	77.7↓	83.8↑
Хүлээгдэж буй борлуулалт	48.8↓	47.4↓	36.9↓

Зураг 8. Үйлчилгээний салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр



Хүснэгт 4. Үйлчилгээний салбарын нэмэлт үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022.III	2022.IV	2023.I
Түүхий эд, материалын үнэ	88.0↑	84.4↓	83.0↓
Үйлчилгээний үнэ	64.5↓	62.8↓	71.1↑
Дуусаагүй ажил үйлчилгээ	54.1↑	56.1↑	47.4↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	47.6↓	56.6↑	73.1↑


3. ААН-ийн ажиллагсдын тооны бүлгээр

Ажиллагсдын тооны бүлэг: Аж ахуйн нэгжүүдийг ажилчдын тоогоор жижиг (50 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан тайлант улирлын худалдан авалтын менежерийн индексийн утгыг тооцвол том ААН-үүдийн индексийн утга 4 улирал дараалан, дунд ААН-үүдийн индексийн утга анхны удаа тэлэлтийн мужид гарсан бол жижиг ААН-үүдийн индексийн утга 9 улирал дараалан агших мужид гарч байна. Гэсэн хэдий ч өмнөх улирлын утгаас жижиг ААН-үүд 3.5 нэгж хувиар, дунд ААН-үүд 2.8 нэгж хувиар, том ААН-үүд 2.5 нэгж хувиар тус бүр өсөж, харгалзан 44.8%, 52.2%, 56.9%-тай гарлаа /Зураг 9/.


Жижиг: Жижиг ААН-үүдийн хувьд шинэ захиалга, үйлдвэрлэл, ажил эрхлэлт болон бараа материалын нөөцийн үзүүлэлтүүдийн индексийн утга 9 улирал дараалан агших мужид гарсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга анх удаа тэлэлтийн мужид шилжлээ. Өмнөх улиралтай харьцуулахад ажил эрхлэлтийн индексийн утга буурсан бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга өссөн дүр зурагтай байна /Зураг 10/.

Дунд: Тус ангилалд хамаарах ААН-үүдийн хувьд ажил эрхлэлт, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа болон бараа материалын нөөцийн индексийн утгууд агших мужаас тэлэлтийн муж руу шилжиж, үйлдвэрлэл 2 улирал дараалан тэлэлтийн мужид гарлаа. Харин шинэ захиалгын индексийн утга 3 улирал дараалан агших мужид гарсан байна. Үзүүлэлтүүдийг өмнөх улиралтай харьцуулахад шинэ захиалгын индексийн утга буурсан бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга өслөө /Зураг 11/.


Зураг 9. Байгууллагын хэмжээгээр



Зураг 10. Жижиг ААН-үүд, үзүүлэлтүүдээр




Зураг 11. Дунд ААН-үүд үзүүлэлтүүдээр




Зураг 12. Том ААН-үүд үзүүлэлтүүдээр

Том: Том ААН-үүдийн хувьд ажил эрхлэлт 7, шинэ захиалга болон үйлдвэрлэл тус бүр 4 улирал дараалан, бараа материалын нөөцийн индексийн утга тэлэлтийн мужид шилжиж гарлаа. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга 9 улирал дараалан агших мужид гарсан байна. Үзүүлэлтүүдийг өмнөх улиралтай харьцуулахад шинэ захиалга болон нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга буурсан бол бусад үзүүлэлтүүдийн индексийн утга өслөө /Зураг 12/.



4. Олон улсын PMI индекс

Зураг 13. Монгол болон худалдааны голлох түнш улсуудын PMI



Худалдааны голлох түнш улсуудын PMI¹: 2023 оны I улиралд² худалдааны голлох түнш улсууд болох БНХАУ, ОХУ, Евро бүс болон дэлхийн ерөнхий индекс өмнөх улирлаас өсөж, агших мужаас тэлэлтийн мужид шилжсэн. Харин АНУ-ын ерөнхий индексийн утга агших мужид хэвээр байна. БНХАУ-д Ковид-19 цар тахлын хөл хориог цуцалсантай холбоотойгоор үйлчилгээний салбар идэвхижиж, улмаар нийт бизнесийн идэвхжил нэмэгдсэнээр нийлмэл индексийн утга 2022 оны 6-р сараас хойшхи хамгийн хамгийн хурдацтай өсөлтийг үзүүлсэн байна. ОХУ-д аж үйлдвэрийн салбарын гадаад эрэлт бага байсан ч үйлчилгээний салбарт эрэлт нэмэгдсэнээр, хувийн хэвшлийн нийт бизнесийн идэвхжил нэмэгдэж индексийн утга өссөн байна. Евро бүсийн хувьд 2023 эхний улиралд гадаад эрэлт сул байсан ч дотоод эрэлт нэмэгдсэнээр хувийн хэвшлийн бизнесийн идэвхжил 3 сар дараалан тэлж 2022 оны 5-р сараас хойшхи хамгийн

¹ Голлох түнш улсуудын PMI индексийн сарын үзүүлэлтийг дундажлан тооцсон болно.

² 2023 оны 1, 2 болон 3 дугаар сарын үзүүлэлтийг дунджилсан болно.

хурдацтай өсөлттэй улирал болсон байна. АНУ-д 1-р сард нийт бизнесийн идэвхжил сул байсан ч 2,3-р сард нэмэгдсэн бөгөөд үүнд ялангуяа үйлчилгэний салбарын эрэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Дэлхийн PMI индекс өсөхөд мөн адил үйлчилгээний салбарын эрэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бөгөөд үйлдвэрлэлийн индексийн утга сүүлийн 9 сарын дээд хэмжээнд хүрч хурдацтай өссөн байна. /Зураг 13/.

5. Хавсралт

ААН-ийн ерөнхий мэдээлэл

Судалгааны түүвэрлэлт хийхдээ аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа (бөөний болон жижиглэн) болон үйлчилгээний салбаруудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эх олонлогийг төлөөлөхүйц 500 орчим ААН-үүдийг **жижиг** (49 хүртэл ажилтантай), **дунд** (50-199 хүртэл ажилтантай), **том** (200-с дээш ажилтантай) гэж ангилан түүвэрлэлт хийсэн бөгөөд ингэхдээ тухайн ангилалд хамаарах бүх аж ахуйн нэгжүүдээс жилийн борлуулалтын орлогоор тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонголоо.

Санал асуулгыг **2023 оны 4 дүгээр сарын 4-өөс 2023 оны 4 дүгээр сарын 21-ийн өдөр** хүртэл **533** аж ахуйн нэгжийн дунд явуулсан бөгөөд **аж үйлдвэрийн салбарын 224, барилгын салбарын 86, дотоод худалдааны салбарын 93, үйлчилгээний салбарын 130** аж ахуйн нэгж судалгаанд хамрагдлаа. Ажилчдын тоогоор жижиг ангилалд хамаарах 355 (67%), дунд 128 (24%), том 50 (9%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, ажилтны тооны бүлгээр³

Ерөнхий салбар	Салбар	ААН-ийн тоо 2023.1*	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр (125)	Уул уурхай, олборлолт	944	10	6	3	19	4%
	Боловсруулах үйлдвэрлэл	6,068	128	43	22	193	36%
	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	265	5	2	1	8	2%
	Усан хангамж	228	4			4	1%
Барилга	Барилга	7,252	49	28	9	86	16%
Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдаа	33,485	76	13	4	93	17%
Үйлчилгээ (142)	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2,886	15	7	3	25	5%
	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажилл	2,575	6	1	1	8	2%
	Мэдээлэл, холбоо	2,544	13	2		15	3%
	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1,919	2	5		7	1%
	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,166	2	2		4	1%
	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн ү.а	5,580	3	2		5	1%
	Боловсрол	3,630	4	3	2	9	2%
	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,494	2	3	2	7	1%
	Урлаг, үзвэр, тоглоом наадам	973	1	1		2	0%
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6,902	35	10	3	48	9%
Нийт		82,704	355	128	50	533	100%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

³ 2023 оны I улирлын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо,

Жилийн борлуулалтын орлогоор ангилан авч үзвэл 50 хүртэл сая төгрөгийн 22 (4%), 50-300 сая төгрөгийн 70 (13%), 300 саяас 1 тэрбум төгрөгийн 103 (19%), 1-2.5 тэрбум төгрөгийн 82 (15%), 2.5-с дээш тэрбум төгрөгийн орлоготой 256 (48%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагджээ /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, жилийн борлуулалтын орлогын бүлгээр

Ерөнхий салбар	Салбар	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр	50 сая₮ хүртэл	7			7	1%
	50-300 сая₮ хүртэл	31			31	6%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	42	4		46	9%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	33	2	1	36	7%
	2.5 тэрбум₮ дээш	34	45	25	104	20%
Барилга	50 сая₮ хүртэл	2			2	0%
	50-300 сая₮ хүртэл	7	1		8	2%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	5	1		6	1%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	14			14	3%
	2.5 тэрбум₮ дээш	21	26	9	56	11%
Дотоод худалдаа	50 сая₮ хүртэл	6			6	1%
	50-300 сая₮ хүртэл	12			12	2%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	20		1	21	4%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	13	1		14	3%
	2.5 тэрбум₮ дээш	25	12	3	40	8%
Үйлчилгээ	50 сая₮ хүртэл	6	1		7	1%
	50-300 сая₮ хүртэл	19			19	4%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	25	5		30	6%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	13	4	1	18	3%
	2.5 тэрбум₮ дээш	20	26	10	56	11%
Нийт	50 сая₮ хүртэл	21	1		22	4%
	50-300 сая₮ хүртэл	69	1		70	13%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	92	10	1	103	19%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	73	7	2	82	15%
	2.5 тэрбум₮ дээш	100	109	47	256	48%
Нийт		355	128	50	533	100%

Энэхүү судалгаанд 2.5 тэрбум төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлоготой, 49 хүртэл ажилтантай буюу жижиг ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүд түлхүү оролцлоо.

Худалдан авалтын менежерийн индексийн тухай

Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын хувьд эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг харах, үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой үзүүлэлт болдог. PMI нь тооцоход хялбар энгийн аргачлал дээр үндэслэгдэж, албан ёсны статистик тоон мэдээлэл гарахаас өмнө эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ бусад орнуудтай харьцуулалт хийх боломж олгодгоороо давуу талтай. Олон улсын туршлагаас харахад уг индексийг тооцохдоо эдийн засгийн голлох салбаруудын нөлөө бүхий 400 орчим аж ахуйн нэгжүүдийг сонгон түүвэрлэлтэд хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт, бараа материалын нөөц, хүргэлтийн хугацаа болон

бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг судалж, эдгээр үзүүлэлт бүрээр индексийн утгыг тооцон, индексийн өөрчлөлтийг харгалзан дүгнэлт өгдөг.

“Худалдан авалтын менежерийн индекс (Purchasing manager index-PMI)” нь эдийн засгийн ерөнхий хандлагыг харуулсан чиглэлийн индекс юм.

Аргачлал: Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үзүүлэлт тус бүрийн хувьд өмнөх улирлаас хэрхэн өөрчлөгдсөн талаар чанарын асуулт асууж, хариултуудыг нэгтгэх замаар тоон буюу индексийн утгад шилжүүлнэ. Индексийг үзүүлэлт тус бүрээр тооцон гаргаж салбаруудын индекс, нийлмэл индекс, нийт эдийн засгийн индексийг тооцоолоход ашиглана.

$$PMI \text{ (тухайн үзүүлэлтийн тархалтын индекс)} = (K1 * 1) + (K2 * 0.5) + (K3 * 0)$$

k1 = Өссөн гэсэн хариултын хувь

k2 = Хэвэндээ гэсэн хариултын хувь

k3 = Буурсан гэсэн хариултын хувь

Уг индексийн тооцоолсон утгыг **тархалтын индекс** гэж нэрлэх бөгөөд PMI=50 бол бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүйг, PMI>50 бол бизнесийн үйл ажиллагааны тэлэлтийг, PMI<50 бол агшилтыг тус тус илэрхийлдэг. Энэхүү утга 50-аас холдох тусам тэлэлт эсвэл агшилт ихэснэ. Тодруулбал, PMI-ийн үзүүлэлт өмнөх улирлын үзүүлэлтээс өндөр байвал эдийн засаг илүү хурдтай тэлж (агшиж) байгааг, харин өмнөх улирлаас доогуур байвал илүү багаар тэлж (агшиж) байна гэсэн утгыг илэрхийлнэ.

Энэхүү судалгаанд PMI-ийг эдийн засгийн голлох салбаруудаар тооцохын зэрэгцээ аж ахуйн нэгжийн ажилчдын тоог нь харгалзан жижиг (49 хүртэл), дунд (50-199), том (200-с дээш) гэж ангилан, бүлэг тус бүрээр индексийг тооцож гаргасан. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогын нийт борлуулалтын орлогод эзлэх хувиар нь бүлэг тус бүрийн үзүүлэлтийн тархалтын индексийг жигнэж тухайн үзүүлэлтийн салбар бүр дэх индексийн утгыг тооцлоо. Салбар болон нийт эдийн засгийн PMI-ийг тооцохдоо гол үзүүлэлтүүдийн нийлмэл⁴ индексийг олон улсад нийтлэг ашиглагддаг ач холбогдлын жингээр⁵ жигнэн тооцсон болно.

⁴ Салбар бүр дэх гол 5 үзүүлэлтүүдийн индексийг ДНБ-д эзлэх хувиар жигнэн тооцсон үзүүлэлт болно.

⁵ Олон улсын туршлагаар PMI-ийг тооцохдоо шинэ захиалга 30%, үйлдвэрлэлийн хэмжээ 25%, ажил эрхлэлт 20%, нийлүүлэлт хугацаа 15%, бараа материалын нөөц 10%-иар жигнэж тооцдог байна. An introduction to the PMI surveys, HIS Markit/.

Аж үйлдвэр

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I
Аж үйлдвэр	40.0%	40.9%	54.9%	52.1%	41.6%	56.2%	52.9%	59.8%	54.2%
Шинэ захиалга	36.3%	40.5%	66.6%	62.4%	47.9%	60.1%	61.6%	66.0%	47.9%
Үйлдвэрлэл	36.1%	40.8%	61.7%	61.0%	43.5%	56.8%	56.6%	63.6%	55.0%
Ажил эрхлэлт	53.9%	45.1%	57.7%	58.5%	63.3%	60.6%	52.3%	71.8%	59.3%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	37.2%	31.2%	23.3%	14.1%	10.6%	37.3%	35.8%	45.6%	54.2%
Түүхий эд, материалын нөөц	37.3%	48.9%	45.1%	42.8%	21.4%	62.9%	44.5%	29.2%	61.0%
Жижиг									
Шинэ захиалга	34.8%	38.6%	48.9%	44.9%	30.7%	32.8%	37.2%	38.6%	41.1%
Үйлдвэрлэл	32.0%	38.6%	46.6%	35.2%	29.5%	34.5%	38.6%	44.7%	42.1%
Ажил эрхлэлт	50.0%	43.2%	43.2%	48.9%	43.8%	40.8%	41.6%	45.2%	41.4%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	40.4%	49.4%	42.6%	43.8%	25.0%	50.0%	42.6%	48.1%	52.6%
Түүхий эд, материалын нөөц	38.8%	33.5%	43.8%	39.8%	34.1%	35.6%	29.6%	36.7%	42.0%
Дуусаагүй үйлдвэрлэл	40.4%	43.2%	47.7%	46.0%	32.4%	50.0%	57.2%	48.7%	51.3%
Бэлэн бүтээгдэхүүн	36.0%	40.3%	44.9%	43.2%	32.4%	37.9%	34.1%	42.6%	43.9%
Бүтээгдэхүүний үнэ	65.2%	65.3%	64.2%	73.3%	66.5%	83.3%	70.4%	78.3%	72.2%
Худалдан авалтын тоо хэмжээ	44.9%	54.0%	61.4%	46.0%	51.1%	34.5%	40.4%	36.1%	39.9%
Түүхий эд, материалын үнэ	86.5%	88.6%	85.2%	85.2%	84.1%	92.5%	89.2%	90.7%	85.8%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	59.6%	57.4%	61.4%	46.0%	58.5%	55.1%	36.5%	63.8%	57.1%
Дунд									
Шинэ захиалга	37.0%	48.0%	44.0%	50.0%	30.0%	50.0%	50.0%	52.0%	51.0%
Үйлдвэрлэл	37.0%	52.0%	38.0%	40.0%	32.0%	52.0%	48.1%	63.0%	53.9%
Ажил эрхлэлт	50.0%	48.0%	46.0%	50.0%	52.0%	50.0%	42.3%	48.1%	52.9%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	43.5%	26.0%	42.0%	32.0%	12.0%	38.0%	38.5%	48.0%	43.9%
Түүхий эд, материалын нөөц	47.8%	52.0%	48.0%	20.0%	32.0%	42.0%	44.0%	35.2%	50.0%
Дуусаагүй үйлдвэрлэл	41.3%	56.0%	58.0%	48.0%	48.0%	60.0%	58.3%	55.8%	46.7%
Бэлэн бүтээгдэхүүн	50.0%	56.0%	60.0%	48.0%	48.0%	44.0%	47.9%	46.3%	55.1%
Бүтээгдэхүүний үнэ	58.7%	66.0%	68.0%	64.0%	76.0%	88.0%	78.8%	73.1%	79.4%
Худалдан авалтын тоо хэмжээ	56.5%	60.0%	50.0%	56.0%	50.0%	56.0%	47.7%	51.9%	50.0%
Түүхий эд, материалын үнэ	82.6%	86.0%	90.0%	84.0%	88.0%	92.0%	88.0%	94.2%	93.0%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	56.5%	54.0%	60.0%	60.0%	52.0%	45.5%	36.4%	69.6%	63.0%
Том									
Шинэ захиалга	36.4%	40.0%	70.0%	65.0%	50.0%	63.6%	65.0%	70.0%	47.9%
Үйлдвэрлэл	36.4%	40.0%	65.0%	65.0%	45.0%	59.1%	59.1%	65.0%	56.0%
Ажил эрхлэлт	54.5%	45.0%	60.0%	60.0%	65.0%	63.6%	54.5%	77.3%	61.5%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	36.4%	30.0%	20.0%	10.0%	10.0%	36.4%	35.0%	45.0%	56.0%
Түүхий эд, материалын нөөц	36.4%	50.0%	45.0%	45.0%	20.0%	68.2%	45.5%	27.8%	64.0%
Дуусаагүй үйлдвэрлэл	36.4%	40.0%	50.0%	55.0%	40.0%	59.1%	65.0%	50.0%	52.2%
Бэлэн бүтээгдэхүүн	54.5%	55.0%	35.0%	60.0%	40.0%	68.2%	54.5%	33.3%	65.4%
Бүтээгдэхүүний үнэ	72.7%	55.0%	80.0%	80.0%	75.0%	86.4%	85.0%	68.2%	80.0%
Худалдан авалтын тоо хэмжээ	27.3%	50.0%	45.0%	65.0%	60.0%	77.3%	70.0%	60.0%	53.8%
Түүхий эд, материалын үнэ	86.4%	75.0%	95.0%	100.0%	100.0%	81.8%	95.0%	88.9%	86.5%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	63.6%	60.0%	65.0%	85.0%	65.0%	83.3%	38.9%	59.1%	53.8%

Барилга

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I
Барилга	29.9%	38.7%	36.5%	31.4%	38.0%	36.3%	36.4%	29.7%	44.5%
Шинэ захиалга	25.7%	43.3%	44.7%	32.9%	37.0%	30.7%	34.1%	21.0%	35.4%
Үйлдвэрлэл	23.3%	39.0%	39.0%	33.6%	32.8%	35.6%	35.7%	26.8%	40.8%
Ажил эрхлэлт	43.2%	47.1%	40.9%	35.8%	47.1%	37.8%	38.8%	30.4%	59.3%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	34.4%	23.8%	19.2%	28.7%	43.7%	58.4%	49.4%	58.7%	48.4%
Түүхий эд, материалын нөөц	25.8%	29.3%	23.2%	16.2%	27.0%	18.6%	21.0%	17.8%	45.0%
Жижиг									
Шинэ захиалга	25.6%	35.0%	42.5%	35.0%	33.3%	27.8%	28.6%	25.6%	39.3%
Үйлдвэрлэл	22.2%	31.3%	42.5%	36.3%	29.8%	30.0%	31.0%	26.1%	47.5%
Ажил эрхлэлт	43.3%	47.5%	45.0%	41.3%	44.0%	36.7%	34.3%	31.6%	41.1%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	41.1%	37.5%	26.3%	28.8%	46.4%	53.3%	59.6%	62.0%	54.5%
Түүхий эд, материалын нөөц	25.6%	27.5%	32.5%	25.0%	20.2%	12.2%	22.5%	21.9%	38.6%
Худалдан авалтын тоо хэмжээ	22.2%	40.0%	45.0%	31.3%	35.7%	42.2%	37.8%	32.6%	42.2%
Түүхий эд, материалын үнэ	92.2%	93.8%	91.3%	87.5%	82.1%	90.0%	92.9%	93.8%	89.8%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	24.3%	45.5%	58.3%	48.6%	47.6%	43.3%	36.4%	21.1%	33.3%
Борлуулалтын үйл ажиллагаа	14.4%	40.0%	42.5%	40.0%	33.3%	37.8%	34.8%	27.3%	67.8%
Барилга, усралтын үйл ажиллагаа	16.7%	45.0%	41.3%	36.3%	34.5%	38.9%	38.5%	25.6%	41.2%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	43.3%	48.8%	40.0%	37.5%	45.2%	41.1%	47.7%	44.3%	47.1%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	77.8%	60.0%	26.3%	45.0%	75.0%	43.5%	36.9%	57.3%	53.3%
Дунд									
Шинэ захиалга	30.5%	50.0%	44.4%	22.2%	34.4%	31.0%	27.6%	22.9%	42.9%
Үйлдвэрлэл	26.8%	38.9%	34.4%	25.6%	32.2%	32.1%	36.9%	27.9%	50.0%
Ажил эрхлэлт	47.6%	46.7%	38.9%	37.8%	43.3%	35.7%	33.3%	24.3%	62.0%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	28.0%	22.2%	17.8%	34.4%	40.0%	58.3%	70.3%	62.5%	54.0%
Түүхий эд, материалын нөөц	25.6%	28.9%	22.2%	11.1%	23.3%	9.5%	17.1%	16.2%	56.0%
Худалдан авалтын тоо хэмжээ	26.8%	46.7%	38.9%	17.8%	41.1%	42.9%	30.3%	27.9%	52.0%
Түүхий эд, материалын үнэ	91.5%	90.0%	94.4%	91.1%	85.6%	88.1%	93.8%	94.6%	92.0%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	38.9%	52.6%	55.4%	37.2%	51.1%	44.0%	33.9%	34.6%	35.3%
Борлуулалтын үйл ажиллагаа	29.3%	40.0%	42.2%	26.7%	34.4%	26.2%	32.1%	26.6%	73.1%
Барилга, усралтын үйл ажиллагаа	28.0%	51.1%	46.7%	21.1%	32.2%	34.5%	26.9%	25.8%	58.8%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	43.9%	53.3%	46.7%	25.6%	47.8%	45.2%	37.1%	27.6%	50.0%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	72.0%	62.2%	30.0%	41.1%	68.9%	42.4%	27.6%	63.0%	53.8%
Том									
Шинэ захиалга	16.1%	43.1%	45.8%	38.9%	41.2%	32.4%	41.4%	17.9%	30.0%
Үйлдвэрлэл	17.9%	43.1%	40.3%	37.5%	35.3%	41.2%	37.9%	26.7%	33.3%
Ажил эрхлэлт	33.9%	47.2%	40.3%	31.9%	51.5%	39.7%	44.8%	32.8%	66.7%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	35.7%	18.1%	16.7%	25.0%	44.1%	61.8%	30.8%	55.4%	42.9%
Түүхий эд, материалын нөөц	26.8%	30.6%	19.4%	15.3%	33.8%	27.9%	22.4%	16.7%	42.9%
Худалдан авалтын тоо хэмжээ	21.4%	51.4%	38.9%	22.2%	44.1%	42.6%	36.5%	25.9%	33.3%
Түүхий эд, материалын үнэ	78.6%	100.0%	98.6%	81.9%	79.4%	79.4%	96.6%	89.3%	100.0%
Орон сууцны зах зээлийн идэвхжил	28.0%	53.6%	55.4%	37.1%	41.2%	42.6%	47.7%	16.7%	50.0%
Борлуулалтын үйл ажиллагаа	14.3%	40.3%	47.2%	36.1%	42.6%	39.7%	53.8%	23.2%	78.6%
Барилга, усралтын үйл ажиллагаа	25.0%	44.4%	54.2%	34.7%	41.2%	36.8%	39.7%	20.7%	25.0%
Туслан гүйцэтгэгч ашиглалт	37.5%	44.4%	48.6%	33.3%	48.5%	48.5%	53.8%	33.3%	50.0%
Бизнесийн үйл ажиллагааны төлөв	69.6%	66.7%	36.1%	50.0%	58.8%	53.1%	41.1%	54.2%	62.5%

Дотоодын худалдаа

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I
Дотоод худалдаа	33.1%	36.4%	43.3%	45.7%	33.5%	46.4%	37.7%	41.0%	56.0%
Шинэ захиалга	22.7%	31.4%	42.5%	46.5%	39.1%	45.4%	34.8%	44.8%	54.1%
Үйлдвэрлэл	29.1%	36.2%	47.3%	52.6%	23.7%	50.8%	37.1%	27.8%	68.1%
Ажил эрхлэлт	47.8%	44.7%	49.6%	51.6%	47.8%	49.2%	43.3%	44.7%	53.7%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	42.1%	35.8%	36.4%	29.7%	19.7%	43.6%	35.2%	43.6%	42.4%
Түүхий эд, материалын нөөц	31.1%	36.4%	33.7%	37.9%	33.1%	36.4%	40.7%	51.1%	56.4%
Жижиг									
Шинэ захиалга	21.1%	32.6%	40.0%	34.2%	38.9%	42.6%	32.6%	37.6%	46.5%
Үйлдвэрлэл	23.7%	33.7%	45.8%	42.1%	26.8%	44.2%	32.8%	19.2%	50.7%
Ажил эрхлэлт	43.2%	41.6%	47.4%	47.4%	45.8%	44.2%	43.0%	38.8%	40.8%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	46.8%	40.5%	32.1%	32.6%	21.1%	42.1%	41.8%	45.6%	46.9%
Түүхий эд, материалын нөөц	34.2%	32.6%	30.5%	28.9%	33.2%	37.4%	44.4%	50.0%	44.8%
Худалдан авсан барааны дундаж үнэ	70.5%	71.1%	79.5%	82.1%	82.1%	79.5%	83.5%	90.4%	81.9%
Худалдан авсан барааны хэмжээ	55.3%	54.7%	63.7%	58.9%	69.5%	75.3%	80.8%	82.1%	88.4%
Хүлээгдэж буй борлуулалт	11.1%	19.5%	17.9%	24.2%	20.0%	61.1%	41.5%	50.0%	26.3%
Дунд									
Шинэ захиалга	21.9%	31.3%	43.8%	50.0%	37.5%	40.6%	38.2%	39.5%	54.5%
Үйлдвэрлэл	31.3%	34.4%	59.4%	53.1%	37.5%	56.3%	41.7%	22.7%	69.2%
Ажил эрхлэлт	43.8%	40.6%	56.3%	56.3%	59.4%	46.9%	44.7%	47.4%	65.4%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	31.3%	21.9%	12.5%	18.8%	15.6%	43.8%	31.6%	26.3%	50.0%
Түүхий эд, материалын нөөц	37.5%	25.0%	40.6%	62.5%	40.6%	25.0%	44.7%	55.6%	62.5%
Худалдан авсан барааны дундаж үнэ	75.0%	71.9%	90.6%	96.9%	90.6%	84.4%	84.2%	94.7%	72.7%
Худалдан авсан барааны хэмжээ	53.1%	62.5%	78.1%	68.8%	68.8%	87.5%	85.3%	89.5%	90.9%
Хүлээгдэж буй борлуулалт	18.8%	12.5%	18.8%	31.3%	15.6%	66.7%	39.5%	52.8%	34.6%
Том									
Шинэ захиалга	25.0%	30.0%	45.0%	60.0%	40.0%	50.0%	35.7%	55.6%	62.5%
Үйлдвэрлэл	35.0%	40.0%	45.0%	65.0%	15.0%	55.0%	40.0%	40.0%	87.5%
Ажил эрхлэлт	55.0%	50.0%	50.0%	55.0%	45.0%	55.0%	42.9%	50.0%	62.5%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	40.0%	35.0%	50.0%	30.0%	20.0%	45.0%	28.6%	50.0%	33.3%
Түүхий эд, материалын нөөц	25.0%	45.0%	35.0%	40.0%	30.0%	40.0%	33.3%	50.0%	66.7%
Худалдан авсан барааны дундаж үнэ	75.0%	85.0%	65.0%	85.0%	75.0%	75.0%	92.9%	77.8%	62.5%
Худалдан авсан барааны хэмжээ	55.0%	65.0%	65.0%	70.0%	60.0%	80.0%	83.3%	66.7%	75.0%
Хүлээгдэж буй борлуулалт	20.0%	30.0%	30.0%	45.0%	20.0%	42.9%	64.3%	41.7%	50.0%

Үйлчилгээ

Үзүүлэлт	2021.I	2021.II	2021.III	2021.IV	2022.I	2022.II	2022.III	2022.IV	2023.I
Үйлчилгээ	31.0%	40.4%	41.0%	42.2%	44.1%	55.3%	51.2%	51.3%	54.8%
Шинэ захиалга	30.3%	38.9%	42.9%	41.3%	43.5%	56.0%	47.5%	51.6%	52.2%
Борлуулалтын орлого	28.4%	42.2%	45.6%	48.5%	49.0%	53.4%	55.7%	50.4%	66.2%
Ажил эрхлэлт	39.1%	51.1%	47.7%	54.0%	53.7%	63.0%	53.9%	52.1%	58.9%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	26.2%	26.5%	21.5%	18.6%	25.1%	47.0%	47.4%	51.3%	36.5%
Жижиг									
Шинэ захиалга	18.2%	33.3%	45.8%	45.2%	39.3%	45.2%	40.4%	38.5%	46.2%
Борлуулалтын орлого	17.5%	35.7%	47.0%	48.8%	41.7%	48.2%	44.6%	43.4%	50.0%
Ажил эрхлэлт	43.5%	46.4%	39.3%	48.2%	50.6%	48.8%	48.8%	42.2%	40.1%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	39.6%	29.8%	29.8%	20.8%	19.6%	45.8%	42.4%	52.1%	51.4%
<i>Түүхий эд, материалын үнэ</i>	76.6%	83.9%	88.1%	92.9%	89.3%	83.9%	89.0%	92.5%	85.0%
<i>Үйлчилгээний үнэ</i>	43.5%	50.0%	53.0%	57.7%	56.5%	72.0%	67.5%	70.6%	68.5%
<i>Дуусаагүй ажил үйлчилгээ</i>	53.2%	62.5%	60.7%	61.9%	57.1%	56.0%	68.8%	61.0%	55.1%
<i>Бизнесийн үйл ажиллагааны төлөв</i>	46.8%	53.0%	43.5%	52.4%	65.5%	53.6%	36.0%	52.5%	59.9%
Дунд									
Шинэ захиалга	23.9%	43.1%	32.8%	32.8%	37.9%	56.7%	40.4%	53.3%	45.3%
Борлуулалтын орлого	23.9%	43.1%	37.9%	36.2%	39.7%	60.0%	51.7%	54.8%	51.4%
Ажил эрхлэлт	39.1%	50.0%	37.9%	48.3%	43.1%	55.0%	51.7%	54.8%	51.4%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	26.1%	29.3%	27.6%	25.9%	19.0%	45.0%	38.9%	55.3%	59.4%
<i>Түүхий эд, материалын үнэ</i>	76.1%	63.8%	79.3%	93.1%	75.9%	73.3%	81.0%	84.0%	92.2%
<i>Үйлчилгээний үнэ</i>	52.2%	53.4%	50.0%	55.2%	50.0%	63.3%	53.6%	65.0%	66.7%
<i>Дуусаагүй ажил үйлчилгээ</i>	60.9%	56.9%	56.9%	58.6%	62.1%	63.3%	64.3%	50.0%	53.7%
<i>Бизнесийн үйл ажиллагааны төлөв</i>	39.1%	53.4%	41.4%	50.0%	63.8%	42.0%	43.1%	62.0%	65.3%
Том									
Шинэ захиалга	35.3%	38.6%	45.5%	43.2%	45.5%	57.1%	50.0%	52.9%	55.0%
Борлуулалтын орлого	32.4%	43.2%	47.7%	52.3%	52.3%	52.4%	57.9%	50.0%	72.7%
Ажил эрхлэлт	38.2%	52.3%	52.3%	56.8%	56.8%	66.7%	55.0%	52.6%	63.6%
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	23.5%	25.0%	18.2%	15.9%	27.3%	47.6%	50.0%	50.0%	27.8%
<i>Түүхий эд, материалын үнэ</i>	85.3%	81.8%	90.9%	86.4%	88.6%	76.2%	89.5%	83.3%	80.0%
<i>Үйлчилгээний үнэ</i>	38.2%	47.7%	59.1%	59.1%	56.8%	73.8%	66.7%	61.1%	72.7%
<i>Дуусаагүй ажил үйлчилгээ</i>	47.1%	54.5%	56.8%	56.8%	68.2%	50.0%	50.0%	57.1%	44.4%
<i>Бизнесийн үйл ажиллагааны төлөв</i>	61.8%	70.5%	56.8%	54.5%	54.5%	53.1%	50.0%	55.6%	77.3%